

ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛСАН ИНД-26-ИЙН ХАРЬЦУУЛАЛТ

<p align="center">Нислэгт тэнцэх чадварын нэмэлт шаардлага (Шинэчлэгдэж байгаа) /15 хуудас/ 2010 оны NZ amend.2</p>	<p align="center">АГААРЫН ХӨЛГИЙН НИСЛЭГТ ТЭНЦЭХ ЧАДВАРЫН НЭМЭЛТ ШААРДЛАГУУД (Хүчинтэй мөрдөгдөж байгаа) /12 хуудас (үндсэн дүрэм-28 хуудастай байсан)/ 1997 оны NZ amend.1</p>	<p align="center">Тайлбар</p>
<p>А Бүлэг-Ерөнхий зүйл</p>	<p>А БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ/ GENERAL</p>	
<p>26.1. Зорилго Энэ Дүрэм нь иргэний нисэхийн бусад дүрэмд заасан НТЧ-ын шаардлагаас гадна, Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлөгт тавих НТЧ-ын нэмэлт шаардлагыг тогтооно.</p>	<p>26.1. Зорилго/ Purpose (а) Иргэний нисэхийн багц дүрмүүдэд заагдсан нислэгт тэнцэх чадварын стандартын нэмэлт шаардлагыг тодорхойлоход энэ дүрмийн зорилго оршино.</p>	<p>Орчуулга, найруулга зассан /Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлөг/</p>
<p>В Бүлэг- НТЧ-ын нэмэлт шаардлага</p>	<p>Б БҮЛЭГ. НИСЛЭГТ ТЭНЦЭХ ЧАДВАРЫН НЭМЭЛТ ШААРДЛАГУУД/ ADDITIONAL AIRWORTHINESS REQUIREMENTS</p>	
<p>26.51. НТЧ-ын нэмэлт шаардлага ИНД-21-д заасан НТЧ-ын нэмэлт шаардлагыг энэ Дүрмийн дараах Хавсралтад заасан:</p> <ul style="list-style-type: none"> (1)Хавсралт В - бүх агаарын хөлөг; (2)Хавсралт С - 9-өөс дээш маягаар гэрчилгээжсэн зорчигчийн суудлын багтаамжтай нисэх онгоц; (3)Хавсралт D - 19-өөс дээш маягаар гэрчилгээжсэн зорчигчийн суудлын багтаамжтай нисэх онгоц; (4)Хавсралт E - нисдэг тэрэг. 	<p>26.51. <u>Загварын</u> нислэгт тэнцэх чадварын нэмэлт шаардлагууд/ Additional airworthiness requirements (а) ИНД-21-д заасан нислэгт тэнцэх чадвар (цаашид НТЧ гэх)-ын <u>Загварын</u> стандартын нэмэлт шаардлагыг энэ дүрмийн дараах хавсралтууд тусгасан болно:</p> <ul style="list-style-type: none"> 1/ бүх агаарын хөлгийн хувьд Хавсралт Б; 2/ 9-өөс дээш зорчигчийн суудалтай, маягийн гэрчилгээтэй онгоцны хувьд Хавсралт В; 3/ 19-өөс дээш зорчигчийн суудалтай, маягийн гэрчилгээтэй онгоцны хувьд Хавсралт Г; 4/ нисдэг тэрэгний хувьд Хавсралт Д. 	<p>Орчуулга, найруулга зассан /Загвар гэдэг үг хасагдсан/</p>
<p>26.53. НТЧ-ын нэмэлт шаардлагыг хангах (а) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд дараах этгээд зөвхөн тухайн заасан ангилал, категори, эсхүл агаарын хөлгийн маяг, эсхүл бүрдэл хэсэгт тавих 26.51-д заасан НТЧ-ын нэмэлт шаардлагыг хангах үүрэгтэй:</p> <ul style="list-style-type: none"> (1) НТЧ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч; (2) ИНД-21.505-ын дагуу техникийн өгөгдлийн зөвшөөрөл авах хүсэлт гаргагч; (3) Монгол Улсын бүртгэлийн гэрчилгээ эзэмшигч. <p>(b) Хангаагүй НТЧ-ын нэмэлт шаардлагыг Даргын хүлээн зөвшөөрөхүйц, аюулгүй байдлын дүйцэх түвшний хүчин зүйлээр нөхсөн байх үүрэгтэй.</p> <p>(c) Энэ Дүрмийн НТЧ-ын нэмэлт шаардлагыг хангах</p>	<p>26.53 НТЧ-ын нэмэлт шаардлагын хамаарал/ Relevance of additional airworthiness requirements (а) ИНД 26.51-д тодорхойлсон НТЧ-ын нэмэлт шаардлагууд нь энэ зүйлийн б-д зааснаас бусад дор заагдсан этгээдийн зөвхөн тодорхой ангилал буюу маягийн агаарын хөлөг эсхүл түүний бүрэлдэхүүн хэсэгт хамаарна.</p> <ul style="list-style-type: none"> 1/ НТЧ-ын гэрчилгээ хүссэн өргөдөл гаргагч; 2/ ИНД-21.505-ийн дагуу техникийн өгөгдөл баталгаажуулах өргөдөл гаргагч; 3/ Монгол улсад бүртгэлтэй <u>агаарын хөлгийн</u> бүртгэлийн гэрчилгээ эзэмшигч. <p>(б) НТЧ-ын аливаа нэмэлт шаардлагуудыг хангаагүй тохиолдолд <u>ИНЕГ-ын</u> даргын хүлээн зөвшөөрөхүйц <u>адилтгах</u> хэмжээний аюулгүй ажиллагааны түвшинг <u>зохих хүчин</u> зүйлээр нөхөж хангасан байна.</p>	<p>Орчуулга, найруулга зассан /ИНЕГ-ын дарга-Дарга гэж өөрчлөгдсөн/</p>

<p>шаардлагатай хэрэглэл болон төхөөрөмж нь агаарын хөлгийн үйлдвэрлэгчийн зааварчилгаа, эсхүл Даргын хүлээн зөвшөөрөхүйц бусад холбогдох зааварчилгааны дагуу суурилуулсан байх ёстой ба ИНД-91.539-ийн дагуу тухайн агаарын хөлөгт хамааралтай MEL-д өөрөөр зөвшөөрснөөс бусад тохиолдолд, бүрэн ажиллагаатай нөхцөлд байх шаардлагатай.</p>	<p>(в) Энэхүү дүрмийн дагуу НТЧ-ын нэмэлт шаардлагуудад хамаарах аливаа тоног төхөөрөмж, хэрэглэл нь агаарын хөлгийн үйлдвэрлэгчийн зааварчилгаа эсхүл ИНЕГ-ын даргын хүлээн зөвшөөрсөн зааварчилгааны дагуу суурилагдсан байх бөгөөд ИНД-91-ийн дагуу тухайн агаарын хөлгийн MEL (Minimum equipment list)-ээр зөвшөөрсөнөөс бусад тохиолдолд бүрэн ажиллагаатай байна.</p>	
<p>Хавсралт А-Нөөц</p>	<p>ХАВСРАЛТ А. НӨӨЦ/ RESERVED</p>	
<p>Хавсралт В- Бүх агаарын хөлөг</p>	<p>ХАВСРАЛТ Б. Бүх агаарын хөлгүүдийн хувьд/ All aircraft</p>	
<p>Агаарын хөлгийн гэрчилгээжүүлэлтийн НТЧ-ын нэмэлт шаардлага нь дараах шаардлагыг багтаана:</p>	<p>Бүх агаарын хөлгийг гэрчилгээжүүлэхэд НТЧ-ын дараах нэмэлт шаардлага тавигдана:</p>	
<p>В.1. Хаалга болон ослын гарцын тэмдэглэгээ (а) Хэвийн болон ослын гарц тус бүрд ГАРЦ, эсхүл ОСЛЫН ГАРЦ тэмдэглэгээ болон нээх арга хэлбэрийг дараах байдлаар, ил харагдахуйц тэмдэглэсэн байна: (1) гарцын гадна болон дотор талд; эсхүл (2) агаарын хөлгийн дотор болон гадна талд гарцын хажуугийн гадаргуу дээр. (б) Энэ зүйлийн (а)-д шаардсан гарцыг ажиллуулах бүх зааварчилгаа нь: (1) товч тодорхой; (2) уншихад хялбар үсгээр, тод ялгарах суурь дээр байна.</p>	<p>(а) Ердийн болон аврах гарц, хаалга тус бүрийг хэрхэн нээх зааварчилгаа болон ГАРАХ ХААЛГА, эсхүл АВРАХ ГАРЦ гэсэн тэмдэглэгээг: 1/ хаалга, гарцны гадна болон дотор талд, эсхүл 2/ хаалганы хажуугийн хананы гадна ба дотор талд тус тус хийсэн байна. (б) Энэ хэсгийн (а)-д заагдсан зааварчилгаа нь: 1/ товч тодорхой; 2/ тод дэвсгэр дээр, уншихад хялбар байдлаар бичигдсэн байна.</p>	<p>Emergency exit - “Аврах гарц” гэснийг “ослын гарц” гэж өөрчилсөн. Орчуулга, найруулга зассан</p>
<p>В.2. Багийн гишүүний хамгаалалтын шаардлага ХАА-н зориулалттай хязгаарлалттай категориор гэрчилгээжсэн байх шаардлагатай агаарын хөлөг нь 1965 оны 02 сарын 01-нд хүчинтэй болсон АНУ-ын Civil Aeronautics Manual 8-ын Appendix В-ын Section.35-д заасан багийн гишүүний хамгаалалтын шаардлагыг хангасан байна.</p>		<p>Орхигдуулсан заалт нөхөж оруулсан</p>
<p>Хавсралт С 9-өөс дээш зорчигчтой нисэх онгоц</p>	<p>ХАВСРАЛТ В. 9-өөс дээш зорчигчийн суудалтай, маягийн гэрчилгээтэй онгоцны хувьд/ Air transport aeroplanes with a type certificated seating capacity of more than 9. Passengers</p>	
<p>9-өөс дээш маягаар гэрчилгээжсэн зорчигчийн суудлын багтаамжтай нисэх онгоцны НТЧ-ын гэрчилгээжүүлэлтийн нэмэлт шаардлага нь Хавсралт В-ээс гадна дараах шаардлагыг багтаана:</p>	<p>9-өөс дээш зорчигчийн суудалтай, маягийн гэрчилгээтэй онгоц онд гэрчилгээ олгохдоо Хавсралт Б-д дурдсан шаардлагаас гадна дараах зүйлүүдийг шаардана:</p>	<p>Орчуулга, найруулга зассан /агаарын тээврын нисэх онгоц гэж тодотгосон/</p>
<p>С.1. Хаалга болон гарц Гадна хаалга болон гарц нь: (1) дотор талаасаа болон нисэх багийн бүхээг нь гүйдэг цонхон гарцтай байхаас бусад тохиолдолд гадна талаасаа нээгддэг байх; (2) суудал, суудлын түшлэг, эсхүл бусад төхөөрөмжөөр халхлагдаагүй байх; (3) дараах хэрэгслээр тоноглогдсон байх:</p>	<p>В.1 Хаалга, гарц Хаалга, гарц бүр нь - 1/ дотор талаас нь нээж болох, мөн нисэх багийн бүхээгийн хажуугийн нээгддэг цонхноос бусад нь гадна талаас нь нээх боломжтой байна; 2/ хаалга, гарцыг ашиглахад сандал, сандлын түшлэг буюу бусад төхөөрөмжүүд саад болохооргүй байна; 3/ дараах шаардлагыг хангасан байна:</p>	<p>Орчуулга, найруулга зассан /хаалга-гадна хаалга/</p>

<p>(i) нислэгийн үед аливаа этгээд, эсхүл механик гэмтлийн үр дүнд санаандгүй нээгдэхээс сэргийлсэн түгжээгээр;</p> <p>(ii) хаалгыг нээх эхний хөдөлгөөн нь гадагш чиглэдэг бол, багийн гишүүд тухайн хаалга бүрэн хаагдсан бөгөөд түгжигдсэнийг тогтоож болох шууд харагддаг түгжээний механизмаар;</p> <p>(iii) хаалгыг ихэвчлэн нисэх онгоцны ачих, буулгах ажиллагаанд ашигладаг бол, тухайн хаалга бүрэн хаагдаагүй болон түгжигдээгүй байгаа нь багийн гишүүдэд ил харагддаг байх хэрэгслээр.</p>	<p>3.1 нислэгийн үед хүн санамсаргүй нээх, эсхүл механик гэмтлийн улмаас өөрөө нээгдэхээс хамгаалагдсан байх;</p> <p>3.2 хэрэв хаалга нь гадагшаа нээгддэг бол хаалга бүрэн хаагдаж, түгжигдсэн гэдэг нь нисэх багийн гишүүдэд шууд харагдахаар байх;</p> <p>3.3 хэрэв хаалга нь онгоцыг ачаалах, ачааг буулгах ажиллагаанд хэрэглэгддэг бол хаалга бүрэн хаагдаагүй, түгжигдээгүй болох нь багийн гишүүдэд харагдахаар байх.</p>	
<p>C.2. <u>Дүрвэн гарахад болон гарцад тавих шаардлага</u></p> <p>C.2.1. <u>Ослын</u> нэмэлт гарц</p> <p>(a) Зорчигчдын орох хаалга нь 1993 оны 05 сарын 10-нд хүчинтэй болсон АНУ-ын FAR 23-ын шалны түвшний ослын гарцад тавих шаардлагыг хангасан байна.</p> <p>(b) Нисэх онгоцыг зорчигчдын орох хаалганаас гадна, дараах шаардлагыг хангасан нэмэлт ослын гарцаар тоногдсон байна:</p> <p>(1) 16-аас цөөн маягаар гэрчилгээжсэн зорчигчийн суудлын багтаамжтай нисэх онгоцны хувьд, их биеийн хоёр талдаа 1993 оны 05 сарын 10-нд хүчинтэй болсон АНУ-ын FAR 23.807(b)-гийн шаардлагыг хангасан гарц; эсхүл</p> <p>(2) 16-аас 23 хүртэлх маягаар гэрчилгээжсэн зорчигчийн суудлын багтаамжтай нисэх онгоцны хувьд, 1993 оны 05 сарын 10-нд хүчинтэй болсон АНУ-ын FAR 23.807(b)-гийн шаардлагыг хангасан:</p> <p>(i) зорчигчдын орох хаалгатай талд нэмэлт нэг гарц;</p> <p>(ii) зорчигчдын орох хаалганы эсрэг талд хоёр гарц; эсхүл</p> <p>(3) 23-аас дээш маягаар гэрчилгээжсэн зорчигчийн суудлын багтаамжтай нисэх онгоцны хувьд, тухайн нисэх онгоцны маягийн гэрчилгээжүүлэлтийн шаардлагыг хангасан гарц.</p> <p>C.2.2. <u>Ослын гарцын дүрвэн гарах төхөөрөмж</u></p> <p>Агаарын хөлгийн маягийн гэрчилгээжүүлэлтэд шаардлагатай ослын гарц бүр нь:</p> <p>(1) далавчны дээр байрласан байх; эсхүл</p> <p>(2) нисэх онгоц газарт, дугуйгаа буулгасан үед газраас дээш 2 м, эсхүл түүнээс дээш өндөрт байдаг гарцын хувьд,</p>	<p>B.2 <u>Аврах нөхцөл байдал</u></p> <p>B.2.1 <u>Нэмэлт гарцууд</u></p> <p>(a) Зорчигчдын орох хаалганы босго нь шалны төвшингийн хэмжээнд байх тухай АНУ-ын FAR-23-ын шаардлагыг хангасан байна.</p> <p>(б) Онгоц бүр нь зорчигчдын орох, гарах үндсэн хаалганаас гадна дараах зүйлийг багтаасан нэмэлт аврах гарцтай байна:</p> <p>1/ 16 буюу түүнээс цөөн зорчигчийн суудалтай, маягийн гэрчилгээ олгогдсон онгоц нь АНУ-ын FAR 23.807(b)-д шаардсаны дагуу их биений хоёр талдаа;</p> <p>2/ 16-гаас 23 хүртэл зорчигчийн суудалтай, маягийн гэрчилгээ олгогдсон онгоцны хувьд:</p> <p>2.1 зорчигчдын үндсэн хаалга байрлах талд нэмэгдэл нэг аврах гарцтай байх;</p> <p>2.2 зорчигчдын үндсэн хаалганы эсрэг талд хоёр гарцтай байх зэрэг АНУ-ын FAR 23.807(b)-ын шаардлагыг хангасан байх;</p> <p>3/ 23-аас дээш зорчигчийн суудалтай, маягийн гэрчилгээтэй онгоцны хувьд тухайн маягийн онгоцыг гэрчилгээжүүлэхэд тавигдах шаардлагыг хангасан байна.</p> <p>B.2.2 <u>Аврах гарц ба төхөөрөмж</u></p> <p>Агаарын хөлөг бүрт маягийн гэрчилгээ олгоход аврах гарцанд дараах шаардлага тавигдана:</p> <p>1/ далавч нь доор байрлалтай онгоцны хувьд далавчнаас дээш байрласан байх;</p> <p>2/ онгоц дугуйгаа буулгасан байдалд газраас дээш 2 м буюу түүнээс дээш өндөртэй бол хүмүүсийг газарт буулгахад туслах</p>	<p>Орчуулга, найруулга зассан</p> <p>–"Аврах гарц" гэснийг "Ослын гарц"</p>

<p>бүхээгт байгаа хүмүүсийг газарт буулгахад туслах хэрэгсэлтэй байна.</p> <p>C.2.3. <u>Ослын гарцын дотор талын тэмдэглэгээ</u> <u>Ослын</u> гарц бүрийг дараах тэмдгээр тэмдэглэсэн байна: (1) “ГАРЦ” / “EXIT” бичгийг дараах хэлбэрээр бичсэн байх: (i) 25 мм өндөр цагаан үсгээр 50 мм өндөр улаан өнгийн суурь дээр; эсхүл (ii) 25 мм өндөр улаан үсгээр 50 мм өндөр цагаан өнгийн суурь дээр; (2) өөрөө гэрэлтдэг, эсхүл үндсэн гэрэлтүүлгийн системээс хамаарахгүйгээр цахилгаанаар гэрэлтдэг байх; (3) минимум 160 микроламбер тодорцтой гэрэлтдэг байх</p>	<p>хэрэгсэлтэй байна.</p> <p>B.2.3 <u>Аврах гарцын дотор талын тэмдэглэл</u> <u>Аврах</u> гарц бүр дараах таних тэмдгээр тэмдэглэгдсэн байх ба: 1/ ГАРАХ (EXIT) гэсэн үгийг: 1.1 50 мм-ийн өндөртэй улаан дэвсгэр дээр 25 мм өндөртэй цагаан өнгийн үсгээр; 1.2 50 мм-ийн өндөртэй цагаан дэвсгэр дээр 25 мм өндөртэй улаан өнгийн үсгээр бичсэн байна; 2/ өөрөө гэрэлтдэг буюу гэрлийн үндсэн системээс хамааралгүй цахилгаан гэрэлтэй байна; 3/ доод тал нь 160 микроламбертийн тод гэрэлтэй байна.</p>	
<p>C.3. Систем болон төхөөрөмж C.3.1. <u>Газардах ангийн анхааруулах дуут дохио</u> (а) Далавчны <u>флапс</u> болон хураагддаг <u>газардах ангиар</u> тоноглон нисэх онгоц нь <u>газардах ангийн</u> анхааруулах дуут дохионы хэрэгсэлтэй байна. (б) Энэ зүйлийн (с)-д зааснаас бусад тохиолдолд, <u>газардах ангийн анхааруулах дуут дохионы хэрэгсэл</u> нь дараах шаардлагыг хангасан байна: (1) буултад бэлтгэн, далавчны <u>флапсыг</u> буултын хэвийн байрлалд буулгасан тохиолдолд, газардах анги бүрэн бууж, түгжигдээгүй үед тасралтгүй үргэлжлэн ажилладаг байх; (2) гараар тасалж болдоггүй байх. (с) Тухайн агаарын хөлгийг усан дээр буулт үйлдэх конфигурацид орсныг нисэх багийн гишүүд шууд харахаар тоноглон бол энэ зүйлийн (б)(2) нь <u>амфиби-нисэх</u> онгоцонд хамаарахгүй.</p>	<p>B.3 Систем ба тоног төхөөрөмжид тавигдах шаардлага B.3.1 <u>Хөл ангийн дуут дохио</u> (а) Далавчны “<u>закрылка</u>”-тай болон хураагддаг <u>хөл анги</u>тай агаарын хөлөг бүр дугуй буусныг илтгэх дуут дохионы тоноглолтой байна. (б) Энэ хэсгийн (в)-д тодорхойлсноос бусад тохиолдолд <u>хөл ангийн дуут дохионы хэрэгсэл</u> нь: 1/ буулт үйлдэж байгаа онгоцны “<u>закрылка</u>” нь хэвийн байрлалд буусан ба хөл анги бүрэн бууж, түгжээндээ ороогүй тохиолдолд үргэлжилсэн дохио өгч байна; 2/ гар ажиллагаагаар дохиог зогсоох боломжгүй байна. (в) <u>Усан дээр буух зориулалттай</u> онгоцонд энэ хэсгийн (б)-гийн 2/ дахь заалт хамаарахгүй.</p>	<p>Landing gear – “хөл анги” гэснийг газардах анги, Aural warning device – “дуут дохионы тоноглол” гэснийг “анхааруулах дуут дохионы хэрэгсэл” amphibious aeroplane – “усан дээр буух зориулалттай онгоц” гэснийг “амфиби-нисэх онгоц” гэж өөрчилсөн</p>
<p>Хавсралт D 19-өөс дээш зорчигчтой нисэх онгоц</p>	<p>ХАВСРАЛТ Г. 19-өөс дээш зорчигчийн суудалтай, <u>маягийн гэрчилгээтэй онгоц</u>онд тавигдах шаардлага/ Air transport aeroplanes with a type certificated seating capacity of more than 19 passengers</p>	<p>aeroplane with a type certificated-“маягийн гэрчилгээтэй онгоц” гэснийг “маягаар гэрчилгээжсэн онгоц”.</p>
<p>19-өөс дээш <u>маягаар гэрчилгээжсэн</u> зорчигчийн <u>суудлын багтаамжтай</u> нисэх онгоцны гэрчилгээжүүлэлтийн НТЧ-ын нэмэлт шаардлага нь Хавсралт В болон Хавсралт С-д зааснаас гадна дараах шаардлагыг багтаана:</p>	<p><u>Маягийн гэрчилгээтэй</u>, 19-өөс дээш зорчигчийн суудалтай онгоцонд гэрчилгээ олгоход Хавсралт Б ба Хавсралт В-д зааснаас гадна дараах нэмэлт шаардлага тавигдана:</p>	
<p>D.1. Хаалга болон гарц D.1.1. Гарцын төрөл</p>	<p>Г.1 Хаалга, гарц Г.1.1 Гарцны төрлүүд</p>	<p>ventral exit-</p>

<p>Гарцын төрөл нь 1993 оны 03 сарын 29-нд хүчинтэй болсон АНУ-ын FAR 25.807-д заасны дагуу байна.</p> <p>D.1.2. Шалны түвшний гарц Зорчигчийн бүхээгээс нэвтрэх боломжгүй ачааны, эсхүл тээшний бүхээг рүү хөтлөх гарцаас бусад, их биеийн хажуу талын шалны түвшний гарц нь дараах тохиолдолд шалны түвшний ослын гарцын шаардлагыг хангасан байна, хэрэв тухайн гарц нь:</p> <p>(1) 1090 мм-ээс өндөр, 490, 1150 мм-ийн өргөнтэй бол; эсхүл</p> <p>(2) өехийн гарц бол; эсхүл</p> <p>(3) сүүлний нарийссан хэсгийн гарц бол.</p>	<p>Гарах гарцыг АНУ-ын FAR 25.807-д тодорхойлсны дагуу ангилна.</p> <p>Г.1.2 Шалны төвшин дэх гарц Онгоцны ачаа тээшний бүхээг рүү нэвтэрдэг техникийн зориулалттай хаалганаас бусад, их биений хажуугийн байрлалтай дараах гарцуудын босгоны өндөр нь шалны төвшингийн хэмжээнд байх тухай АНУ-ын FAR 23-ын шаардлагыг хангасан байна.</p> <p>1/ 1090 мм-ээс өндөр, 490-1150 мм өргөнтэй хаалга;</p> <p>2/ үйлчилгээний (люк) гарц;</p> <p>3/ онгоцны сүүл хэсэгт гаргасан гарц.</p>	<p>“үйлчилгээний гарц” гэснийг “өехийн гарц”, tail cone exite- “онгоцны сүүл хэсэгт гаргасан гарц” гэснийг “сүүлний нарийссан хэсгийн гарц” .</p>
<p>D.2. Дүрвэн гарахад болон гарцад тавих шаардлага D.2.1. Нэмэлт ослын гарц</p> <p>(a) Тухайн агаарын хөлгийн маягийн гэрчилгээжүүлэлтэд шаардсан зорчигчийн бүхээгийн ослын гарцын тооноос илүү гарсан гарц нь:</p> <p>(1) энэ Хавсралтын холбогдох бүх шаардлагыг хангасан байна;</p> <p>(2) саадгүй хүрч болохоор байна.</p> <p>(b) Турбо-жэт хөдөлгүүртэй нисэх онгоцны өехийн болон сүүлний нарийссан хэсгийн гарц нь:</p> <p>(1) нислэгийн үед нээгдэхгүй байхаар зохион бүтээгдэж, үйлдвэрлэгдсэн байна;</p> <p>(2) дараах зурагт хуудсаар тэмдэглэгдсэн байна:</p> <p>(i) нислэгийн үед гарцыг нээж болохгүйг анхааруулсан;</p> <p>(ii) 750 мм-ийн зайнаас уншигдахуйц;</p> <p>(iii) гарцыг нээх хэрэгслийн ойролцоо ил харагдахуйц байрлалд суурилүүлсан</p>	<p>Г.2 Аврах нөхцөл ба гарцын төрлүүд Г.2.1 Аврах нэмэлт гарц</p> <p>(a) Агаарын хөлөг нь, түүнд маягийн гэрчилгээ олгоход тавигддаг шаардлагаас илүү тооны нэмэлт гарцтай тохиолдолд тэдгээр нь:</p> <p>1/ энэ хавсралтын холбогдох бүх шаардлагуудыг хангасан байна;</p> <p>2/ ашиглахад бэлэн байна.</p> <p>(б) Тийрэлтэт хөдөлгүүртэй онгоцны шалны төвшинтэй ижил төвшингийн болон онгоцны их биений төгсгөлд байрлах аврах гарцууд нь:</p> <p>1/ нислэгийн үед онгойхгүйгээр зохион бүтээгдсэн байна;</p> <p>2/ дараах шаардлагыг хангасан анхааруулгатай байна:</p> <p>2.1 нислэгийн үед хаалгыг онгойлгож болохгүйг сануулсан,</p> <p>2.2 750 мм-ийн зайнаас уншигдахаар,</p> <p>2.3 хаалганы бариулын ойролцоо, нүдэнд харагдахуйц газар байрласан.</p>	<p>“Аврах гарц” гэснийг “ослын гарц”</p> <p>Орчуулга, найруулга зассан</p>
<p>D.2.2. Ослын гарцад хүрэх зам</p> <p>(a) Нэмэлт ослын гарцаас бусад, нисэх онгоцны ослын гарцад хүрэх зам нь дараах шаардлагыг хангасан болохыг бататгана:</p> <p>(1) дараах дамжин хүрэх зам нь саадгүй, 500 мм-ээс доошгүй өргөнтэй байх:</p> <p>(i) зорчигчийн бүхээгийн хэсгүүдийн хооронд;</p> <p>(ii) I, эсхүл II төрлийн ослын гарц руу хөтөлдөг;</p> <p>(2) I болон II төрлийн ослын гарцын зэргэлдээх орон зай нь, багийн гишүүд замын саадгүй өргөнийг 500 мм-ээс бага болгохгүйгээр зорчигчдыг нүүлгэн шилжүүлэхэд туслахад хангалттай байх;</p>	<p>Г.2.2 Аврах гарцанд хүрэх боломж</p> <p>(a) Нэмэлт гарцаас бусад аврах гарцыг ашиглахад дараах шаардлагууд хангагдсан байна:</p> <p>1/ хаалганд хүрэх зам нь аливаа саадгүй байх бөгөөд гарцын харалдаах зорчигчдийн суудал хоорондын зай болон I буюу II ангиллын аврах хаалга тус бүрд хүрэх зай нь 500 мм-ээс доошгүй өргөнтэй байх;</p> <p>2/ Зорчигчдын суудал хоорондын зай 500 мм-ээс багагүй өргөнтэй байх ба энэ замаар багийн гишүүд зорчигчдыг саадгүй нүүлгэн гаргах I ба II ангиллын аврах гарц тус бүрд хүрэх орон зай хангалттай байх.</p>	<p>- “хаалганд хүрэх зам” гэснийг “дамжин хүрэх зам”</p> <p>Орчуулга, найруулга зассан</p>

<p>(3)бүхээгийн үндсэн замаас III болон IV төрлийн гарц бүрд хүрэх зам нь гарцын нэвтрэх боломжийг багасгах суудал, тавиур, эсхүл бусад саадаар халхлагдаагүй байх;</p> <p>(4)зорчигчийн бүхээгийг ослын гарцаас тусгаарлаж байгаа хаалга нь:</p> <p>(i) загварын гэрчилгээжүүлэлтийн стандартад заасны дагуу хүрээлсэн бүтцэд үйлчлэх нийт инерцийн хүчийг даах чадвартай, хөөрөлт болон буултын үед нээлттэй байдалд түгжих хэрэгсэлтэй байх;</p> <p>(ii)хөөрөлт болон буултын үед хаалга нээлттэй байх ёстойг харуулсан зурагт хуудастай байх.</p> <p>(b) Зорчигчийн бүхээгийн хоорондох ослын гарц руу хөтлөх дамжин хүрэх зам бүр нь дамжин хүрэх замаар чөлөөтэй нэвтрэн орох хөшигнөөс өөр саадгүй байна.</p> <p>(c) Зорчигчийн бүхээг хоорондын тусгаарлагчид хаалга суурилуулж болохгүй.</p>	<p>3/ суудлуудын хоорондох гудмаас III ба IV ангиллын аврах гарц хүрэхэд саад болохоор ямар нэг зүйлгүй байх;</p> <p>4/ зорчигчдын бүхээгийг аврах гарцнаас тусгаарлаж буй хаалт, хаалга бүр дараах шаардлагыг хангасан байна:</p> <p>4.1 онгоц хөөрөх, буух бүрд бүхээгийн тусгаарлагчийн хаалтыг нээлттэй байдалд түгжиж бэхэлсэн байх бөгөөд түүний түгжээний болон бусад зүйлийн энерцийн хүчийг давах чадвар нь загварын гэрчилгээний шаардлагад нийцсэн байна;</p> <p>4.2 тухайн хаалга, хаалтууд нь “онгоц хөөрөх ба буух үед нээлттэй” гэсэн бичигтэй байна.</p> <p>(б) Зорчигчдын суудал хоорондын болон бүхээгийн гудам нь хүн явахад (замын хөшгийг тооцолгүйгээр) аливаа саадгүй байх ба түүгээр дамжин аврах гарцанд хүрэхэд чөлөөтэй байна.</p> <p>(в) Зорчигчийн бүхээг хоорондын тусгаарлагч (перегородок) ямар нэг хаалгагүй байна.</p>	
<p>D.2.3. Ослын гарцыг удирдах бариул</p> <p>(a) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, нисэх онгоцны гарц бүрийн ойролцоо, эсхүл дээр дараах тэмдэглэгээтэй байна:</p> <p>(1)тэмдэглэгээ нь 750 мм-ийн зайнаас уншигдахуйц;</p> <p>(2)зорчигчийн ослын гарцыг удирдах бариулын байрлалыг заасан;</p> <p>(3)түгжээний механизм нь бариулын эргэх хөдөлгөөнөөр тайлагддаг I болон II төрлийн ослын гарцыг багтаасан, гарцыг нээх зааварчилгаа нь:</p> <p>(i) 20 мм-ээс багагүй өргөн иштэй, толгой нь ишнээсээ хоёр дахин өргөн, ойролцоогоор бариулын уртын дөрөвний гуравтай тэнцүү радиустай 70°-аас багагүй үргэлжилсэн тойргийн нумтай улаан өнгийн сум;</p> <p>(ii) сумны толгойн ойролцоо хэвтээ байрлуулсан 25мм хэмжээтэй улаан өнгийн үсгээр бичсэн “OPEN” “НЭЭЛТТЭЙ” бичигтэй байна.</p> <p>(b) 1972 оны 05 сарын 01, эсхүл түүнээс хойш маягаар гэрчилгээжсэн нисэх онгоцонд, тухайн нисэх онгоцны маягийн гэрчилгээжүүлэлтийн шаардлагын дагуу тэмдэглэгээ хийсэн байна.</p> <p>(c) <u>Удирдах бариул болон удирдах бариулын бүрхүүл нь минимум 100 микроламберт тодорцтой гэрэлтдэг байна.</u></p>	<p>Г.2.3 Аврах гарц ба хаалганы ажиллуулах (удирдах) бариул</p> <p>(a) Энэ зүйлийн (б)-д зааснаас бусад тохиолдолд онгоцны гарах хаалга, аврах гарцны ойролцоо буюу дээр нь дараах тэмдэг тавина:</p> <p>1/ тэмдэглэгээг 750 мм-ийн зайнаас гаргаж унших боломжтой;</p> <p>2/ аврах хаалга бүрийн ажиллуулах бариулын ойролцоо;</p> <p>3/ бариулыг эргүүлж түгжээг онгойлгодог цоож бүхий I ба II ангиллын гаргах хаалга бүрийг онгойлгох заавар нь:</p> <p>3.1 наад зах нь 20 мм өргөн, толгойн хэсэг нь бариулын хэмжээнээс хоёр дахин өргөн, бариулын уртын дөрөвний гуравтай тэнцүү хэмжээний урттай, 700-ын голч бүхий өнцгөөр тахирласан улаан өнгийн сумаар заах тэмдэг тавьсан;</p> <p>3.2 сумны толгойноос дээш 25 мм орчим зайд улаан өнгийн үсгээр НЭЭЛТТЭЙ (OPEN) гэж бичсэн байна.</p> <p>(б) Маягийн гэрчилгээ олгогдсон онгоцууд нь тэдгээр маягийн гэрчилгээжүүлэх шаардлагын дагуу зохих тэмдэглэгээ хийгдсэн байна.</p> <p>(в) <u>Аврах гарц ба хаалгыг нээж ажиллуулах бариулын гэрэлтүүлэгийн хүч нь 100 микроламберт-аас багагүй тод гэрэлтэй байна.</u></p>	<p>Орчуулга, найруулга зассан</p> <p>-2010 онд Amend.2-өөр (c)-р заалт нэмэгдсэн</p>

<p>D.2.4. <u>Ослын гарцын дүрвэн гарах төхөөрөмж</u></p> <p>(a) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, ослын гарц нь тухайн нисэх онгоцны маягийн гэрчилгээжүүлэлтийн 1972 оны 04 сарын 30-нд хүчинтэй болсон шаардлагыг хангасан, бүхээгт байгаа хүмүүсийг газарт буухад туслах хэрэгсэлтэй байх ёстой.</p> <p>(b) 1972 оны 05 сарын 01, эсхүл түүнээс хойш маягаар гэрчилгээжсэн нисэх онгоцны хувьд, ослын гарц нь тухайн нисэх онгоцны маягийн гэрчилгээжүүлэлтийн шаардлага хангасан, бүхээгт байгаа хүмүүсийг газарт буухад туслах хэрэгсэлтэй байх ёстой.</p> <p>(c) Хэрэв энэ зүйлийн (a) (b)-д шаардсан, бүхээгт байгаа хүмүүсийг газарт буухад туслах хэрэгсэл нь автоматаар дэлгэгддэг бол, энэ нь явгалалт, хөөрөлт болон буултын үед бэлэн байдалд орох чадвартай байх шаардлагатай.</p>	<p>Г.2.4 <u>Хаалганы аврах тоног төхөөрөмж</u></p> <p>(a) Энэ зүйлийн (б)–д зааснаас бусад тохиолдолд, гарах хаалга, гарц бүр онгоцны маягийн гэрчилгээжилтийн шаардлагад нийцсэн, зорчигчдыг газарт буулгах тоног төхөөрөмжтэй байна.</p> <p>(б) Зорчигчдыг газар буухад туслах тоног төхөөрөмж нь автоматаар ажиллан дэлгэгддэг ба онгоцны явгалах, хөөрөх болон буулт үйлдэх үед бэлэн байдалд байна.</p>	<p>Орчуулга, найруулга зассан - “Хаалганы аврах тоног” гэснийг “Ослын гарцын нүүлгэн шилжүүлэх”</p> <p>-2010 онд Amend.2-өөр (c)-р заалт нэмэгдсэн</p>
<p>D.2.5. <u>Ослын гарцын дайжих зам</u></p> <p>(a) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, нисэх онгоц нь тухайн нисэх онгоцны маягийн гэрчилгээжүүлэлтийн 1972 оны 04 сарын 30-нд хүчинтэй болсон шаардлага хангасан, халтирахаас хамгаалсан дайжих замтай байна.</p> <p>(b) 1972 оны 05 сарын 01, эсхүл түүнээс хойш маягаар гэрчилгээжсэн нисэх онгоц бүр нь тухайн нисэх онгоцны маягийн гэрчилгээжүүлэлтийн шаардлага хангасан, халтирахаас хамгаалсан дайжих замтай байна.</p>	<p>Г.2.5 <u>Аврах хаалга, гарцаар гарах зам</u></p> <p>Онгоц бүр, маягийн гэрчилгээ олгоход тавигдах шаардлагад нийцсэн, хальтирч гулсахаас хамгаалагдсан гарах замтай байна.</p>	<p>- “Аврах хаалга, гарцаар гарах зам” гэснийг “Аврах хаалга, гарцаар зам”</p> <p>Орчуулга, найруулга зассан</p>
<p>D.2.6. <u>Ослын гэрэлтүүлэг</u></p> <p>(a) Ослын гэрэлтүүлгийн системд шаардлагатай гэрэл нь:</p> <p>(1) асаах “ON”, унтраах “OFF” бэлэн “ARMED” байрлал бүхий бүхээгийн удирдлагын хэрэгсэлтэй байх;</p> <p>(2) дараах байрлалаас гараар ажиллуулах боломжтой байх:</p> <p>(i) нисэх багийн гишүүдийн хэвийн суусан байрлалаас;</p> <p>(ii) зорчигчийн бүхээгт, бүхээгийн ажилтны хэвийн суудлаас хялбар хүрэх байрлалаас;</p> <p>(3) гар удирдлагыг санаандгүй ажиллуулахаас сэргийлэх хэрэгсэлтэй байх;</p> <p>(4) бэлэн, эсхүл асаалттай байрлалд байгаа үед их бие босоо огтлолоор хуваагдахаас бусад тохиолдолд, нисэх онгоцны үндсэн цахилгаан тэжээл тасрахад асаалттай хэвээр байх, эсхүл асах;</p> <p>(5) онцгой нөхцөлийн буултын дараа гадна орчны хүндрэлтэй нөхцөлд, шаардлагатай гэрэлтүүлгийн түвшнийг 10-аас доошгүй минут хангаж байх.</p>	<p>Г.2.6 <u>Ослын гэрэлтүүлэг</u></p> <p>(a) Ослын гэрэлтүүлгийн системийн гэрэл бүр нь:</p> <p>1/ нисэх багийн бүхээгт, АСААХ, УНТРААХ болон БЭЛЭН гэсэн бичигтэй товчлуур бүхий удирдлагатай байна;</p> <p>2/ дараах байрлалуудаас гараар хялбар ажиллуулах боломжтой байна:</p> <p>2.1 нисэх багийн гишүүдийн суудлаас;</p> <p>2.2 зорчигчийн бүхээг дэх үйлчлэгчийн суудлаас;</p> <p>3/ гараар санамсаргүй ажиллуулахаас хамгаалагдсан байна;</p> <p>4/ БЭЛЭН буюу АСААЛТТАЙ байрлалд байгаа тохиолдолд онгоцны үндсэн цахилгаан тэжээл тасрахад асаалттай хэвээр байх буюу асах;</p> <p>5/ ослын буултын дараа орчны хүнд нөхцөлд наад зах нь 10 минут асч байх.</p>	<p>Орчуулга, найруулга зассан</p>

<p>(b) Бүхээгт байгаа хүмүүсийг газарт буухад туслах хэрэгслийн бүрдүүлэгч хэсэг болох гэрэл нь дараах тохиолдолд, энэ зүйлийн (а)-ийн шаардлагыг хангахгүй байж болно, хэрэв:</p> <p>(1) зөвхөн нэг туслах хэрэгсэлд үйлчилдэг бол;</p> <p>(2) тухайн туслах хэрэгсэл дэлгэгдэхэд автоматаар идэвхэждэг бол;</p> <p>(3) нисэх онгоцны ослын үндсэн гэрэлтүүлгийн системээс тусдаа бие даасан бол.</p>	<p>(б) Зорчигчдыг газарт буулгахад туслах гэрлүүд нь дараах тохиолдолд энэ зүйлийн (а)-гийн шаардлагыг хангахгүй байж болно:</p> <p>1/ зөвхөн нэг тоноглолын хувьд хэрэглэгдэх бол;</p> <p>2/ гулсах шат дэлгэгдэхэд автоматаар идэвхэждэг бол;</p> <p>3/ онгоцны ослын гэрэлтүүлгийн ерөнхий системээс тусдаа, бие даасан тэжээлийн системтэй бол.</p>	
<p>D.2.7. Дотор талын ослын гэрэлтүүлэг Нисэх онгоц нь дараах ослын гэрэлтүүлгийн системтэй байна:</p> <p>(1) үндсэн гэрэлтүүлгийн системээс тусдаа бие даасан тэжээлийн эх үүсвэртэй;</p> <p>(2) зорчигчийн бүхээгийн үндсэн замын гол шугамын дагуу 1 м тутамд, суудлын тохойвчийн өндөрт хэмжсэн дундаж гэрэлтүүлгийн хүч нь 0.54 м-канделаас (0.05 foot-candles) багагүй;</p> <p>(3) гарц бүрийн тэмдэг, тэмдэглэгээг гэрэлтүүлдэг;</p> <p>(4) шалны ойролцоох ослын дайжих замын тэмдэглэгээг багтаасан.</p>	<p>Г.2.7 Дотор талын ослын гэрэлтүүлэг Онгоц бүхэн ослын үед ажиллах гэрэлтүүлгийн системтэй байх бөгөөд энэ нь:</p> <p>1/ үндсэн гэрэлтүүлгийн системээс тусдаа тэжээгдэнэ;</p> <p>2/ зорчигчийн суудлын хоорондын зайн гол шугамын дагуу 1 метр тутамд, зорчигчийн сандлын тохойвчны түвшинд гэрэлтүүлгийн хүч нь 0.538 люминесцент хэмжээтэй байна.</p> <p>3/ гарах хаалга бүрийн тэмдэг, бичгүүдийг гэрэлтүүлнэ;</p> <p>4/ ослын үед мөлхөж гарах замыг заасан гэрлэн тэмдэглэгээнүүдийг шаланд байрлуулсан байна.</p>	<p>Орчуулга, найруулга зассан -“Дотор талын ослын гэрэлтүүлэг” гэснийг “Ослын дотоод гэрэлтүүлэг”</p>
<p>D.2.8. Гадна талын ослын гэрэлтүүлэг (а) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, нисэх онгоц нь 1972 оны 04 сарын 30-нд хүчинтэй болсон, тухайн нисэх онгоцны маягийн гэрчилгээжүүлэлтийн шаардлагыг хангасан, ослын гадна гэрэлтүүлэгтэй байна.</p> <p>(b) 1972 оны 05 сарын 01, эсхүл түүнээс хойш маягаар гэрчилгээжсэн нисэх онгоц бүр нь тухайн нисэх онгоцны маягийн гэрчилгээжүүлэлтийн шаардлага хангасан, ослын гадна гэрэлтүүлэгтэй байна.</p>	<p>Г.2.8 Гадна талын ослын гэрэлтүүлэг Онгоц бүр, тухайн онгоцны маягийн гэрчилгээ олгоход тавигдах шаардлагыг хангасан, гадна талын ослын гэрэлтэй байна.</p>	<p>Орчуулга, найруулга зассан - “Гадна талын ослын гэрэлтүүлэг” гэснийг “Ослын гадна гэрэлтүүлэг” -2 заалт болон задарсан байна</p>
<p>D.2.9. Ослын гарцын дотор талын тэмдэглэгээ (а) Ослын гарц бүрийг болон тэдгээрт хүрэх замын чиглэлийг дараах байдлаар ойлгомжтой, тод харагдахуйц тэмдэглэсэн байна:</p> <p>(1) таних тэмдэг болон байрлал нь бүхээгийн өргөнтэй тэнцүү зайнаас танигдахуйц;</p> <p>(2) нээх арга хэлбэрийг агуулсан.</p> <p>(b) Ослын гарц бүрийн байрлалыг, зорчигчийн бүхээгийн үндсэн замаар ойртож байгаа хүмүүст харагдахуйц тэмдгээр дараах байдлаар тэмдэглэсэн байна:</p> <p>(1) далавчин дээрх ослын гарц бүрийн ойролцоо, гадагшаа гарах замын дээд талд;</p> <p>(2) хэрэв тухайн тэмдгээс хоёр гарцыг хялбар харах</p>	<p>Г.2.9 Аврах гарцны дотор талын тэмдэг, тэмдэглэгээ (а) Аврах хаалга, гарцууд руу очих аргуудыг ойлгомжтой бөгөөд ил тод тэмдэглэсэн байх ба:</p> <p>1/ гарах хаалга нь кабины өргөний хэмжээний зайнаас харагдахаар байна;</p> <p>2/ хаалгыг онгойлгох аргыг заасан байна.</p> <p>(б) Аврах гарц бүрийн тэмдэг, тэмдэглэгээ нь зорчигчдын сандлуудын хоорондох үндсэн гудмаас харагдахаар байна.</p> <p>1/ далавчны дээд талд байрласан аврах гарц бүрийн ойролцоо гадагшаа гарах зам тэмдэглэгдсэн байна;</p> <p>2/ гарах хаалгуудыг нэг тэмдгээр тэмдэглэсэн байж болох</p>	<p>Орчуулга, найруулга зассан -“Аврах гарцны дотор талын тэмдэг, тэмдэглэгээ” гэснийг “Ослын гарцын дотор тэмдэглэгээ”</p>

<p>боломжтой бол, нэг тэмдгээр хоёр гарцыг тэмдэглэхээс бусад тохиолдолд, шалны түвшний ослын гарц бүрийн ойролцоо;</p> <p>(3) зорчигчийн бүхээгийн урд болон хойд хэсгийн харагдах орчныг хязгаарласан тусгаарлагч, эсхүл хөндлөвч дээр халхлагдсан ослын гарцыг заасан тэмдэг тавина.</p> <p>(с) Энэ зүйлийн (d)-д зааснаас бусад тохиолдолд, нисэх онгоц нь 1972 оны 04 сарын 30-нд хүчинтэй болсон тухайн нисэх онгоцны маягийн гэрчилгээжүүлэлтийн шаардлагыг хангасан, ослын гарцын тэмдэг тэмдэглэгээтэй байна.</p> <p>(d) 1972 оны 05 сарын 01, эсхүл түүнээс хойш маягаар гэрчилгээжсэн нисэх онгоц нь тухайн нисэх онгоцны маягийн гэрчилгээжүүлэлтийн шаардлага хангасан, ослын гарцын тэмдэг тэмдэглэгээтэй байна.</p> <p>(e) Ослын гарц бүрийн тэмдэг тэмдэглэгээ нь минимум 250 микроламберт тодорцтой гэрэлтдэг байна.</p>	<p>бөгөөд тухайн тэмдгээр нь хоёр гарцыг хоёуланг нь хялбар олох боломжтой байх, хэрэв тийм биш бол шалны түвшинд байрлалтай аврах гарц бүрийн дэргэд байх;</p> <p>3/ зорчигчдын бүхээгт тасалгаа үүсгэж, хөндлөвч болон хаалт бүрд тэдгээрт далдлагдсан гарах хаалгуудыг заасан тэмдэг тавина.</p> <p>(в) Онгоц бүр тухайн онгоцны маягийн гэрчилгээ олгоход тавигдах шаардлагыг хангасан аврах гарцын тэмдэглэгээтэй байна.</p> <p>(г) Аврах гарцын тэмдэглэгээ бүр доод тал нь 250 микроламберт гэрэлтэй байна.</p>	<p>-“Аврах гарц” гэснийг “Ослын гарц”</p>
<p>D.2.10. Ослын гарцын гадна талын тэмдэглэгээ</p> <p>Гадна талаас нь ажиллуулах боломжтой ослын гарц бүрийг их биеийн гадна талд дараах байдлаар тэмдэглэсэн байх ёстой:</p> <p>(1) гарцыг 50 мм өргөнтэй үргэлжилсэн өнгөт зурвасаар дараах байдлаар тойруулан зурсан байх:</p> <p>(i) хүрээлсэн гадаргуугаас ялгарч харагдуулахын тулд өөр өнгө ашиглаж;</p> <p>(ii) гарцын ирмэг дээр, гарцыг хүрээлсэн гадаргуу дээр, эсхүл гарцын ирмэг болон гарцыг хүрээлсэн гадаргууд хоёулан дээр нь хэсэгчлэн;</p> <p>(2) их биеийн хажуу гадаргууд байрлаагүй гарцын хувьд:</p> <p>(i) гаднаас нээх хэрэгсэл болон холбогдох зааварчилгааг улаан өнгөөр, эсхүл хэрэв улаан өнгө нь суурийн өнгөнөөс хангалттай ялгарч харагдахгүй бол, тод гялалзсан шар өнгөөр;</p> <p>(ii) хэрэв нээх хэрэгсэл нь тухайн их биеийн зөвхөн нэг талд байрладаг бол, нээх зааварчилгааг их биеийн хоёр талд байхаар.</p>	<p>Г.2.10 Аврах гарц болон хаалганы гадна талын тэмдгүүд</p> <p>Гадна талаас нь нээж болох аврах гарц, хаалга бүр нь дараах тэмдгүүдтэй байх бөгөөд:</p> <p>1/ гарах хаалгыг тойруулан зурсан 50 мм өргөн үргэлжилсэн өнгөт зурвас нь:</p> <p>1.1 онгоцны их биений гадаргуугаас тод ялгарч харагдахаар байна;</p> <p>1.2 хаалганы ирмэг дээгүүр, эсхүл хаалганы эргэн тойрны гадаргуу дээр, эсхүл ирмэг ба эргэн тойрны гадаргуу дээр хамтад нь байна;</p> <p>2/ нээх зааварчилгааг улаан юмуу тод шар өнгөөр өгдөг байна;</p> <p>3/ хэрэв гарах хаалга нь их биений зөвхөн нэг талд байдаг бол нөгөө талд нь мөн тэмдэглэгээ хийсэн байна.</p>	<p>-“тэмдгүүд” гэснийг “тэмдэглэгээ”</p> <p>Орчуулга, найруулга зассан</p>
<p>D.3. Ариун цэврийн өрөөний галаас хамгаалах төхөөрөмж</p> <p>(а) Ариун цэврийн өрөө бүрийг тод харагдахуйцаар, дараах байдлаар тэмдэглэсэн байх ёстой:</p> <p>(1) ариун цэврийн өрөөнд тамхи татахыг хориглосон тэмдгийг хаалганы хоёр талд;</p> <p>(2) “саванд тамхи хаяхыг хориглосон” анхааруулсан тэмдгийг ариун цэврийн өрөөний цаасны сав, эсхүл хогийн савны таг дээр.</p>	<p>Г.3 Ариун цэврийн өрөөний галын хамгаалалт</p> <p>(а) Ариун цэврийн өрөө бүрт дараах анхааруулсан тэмдэглэгээ байна:</p> <p>1/ хаалганы хоёр талд ТАМХИ ТАТАХЫГ ХОРИГЛОНО (NO SMOKING) гэсэн анхааруулга;</p> <p>2/ ариун цэврийн өрөөний цаас, хог хаях савны таг дээр ГАЛЫН АЮУЛТАЙ ЗҮЙЛ ХАЯЖ БОЛОХГҮЙ (NO CIGARETTE DISPOSAL) гэсэн анхааруулга.</p>	<p>Орчуулга, найруулга зассан</p>

<p>(b) Зориулалт нь тамхи татахыг хориглосноос бусад нисэх онгоцны хувьд, ариун цэврийн өрөө бүрийн хаалганы гадна талд, эсхүл түүний ойролцоо үнсийг өөртөө агуулдаг салдаг савтай байна.</p> <p>(c) Ариун цэврийн өрөөний цаасны сав, эсхүл хогийн сав нь дараах шаардлагыг хангасан байна: (1) галыг тухайн савандаа барих жийрэг бүхий тагтай байх; (2) хогийн саванд гал гарсан тохиолдолд, автоматаар цацагдахаар зохион бүтээгдсэн, дотор нь суурилуулсан гал унтраагууртай байх.</p> <p>(d) Ариун цэврийн өрөө бүрийг дараах утаа мэдрэгч, эсхүл түүнтэй дүйцэх хэрэгслээр тоноглогдсон байна: (1) нисэх багийн бүхээгт анхааруулах гэрлэн дохио өгдөг; эсхүл (2) багийн гишүүд нислэгийн бүх үе шатанд хялбар илрүүлэх боломжтой анхааруулах гэрлэн, эсхүл дуут дохио өгдөг.</p>	<p>(б) Хогийн сав бүр дараах шаардлагыг хангасан байна:</p> <p>1/ гал асахааргүй битүү тагтай; 2/ хогийн саванд гал гарвал автоматаар унтраах гал унтраагч суулгасан байна.</p> <p>(в) Ариун цэврийн өрөө бүр утаа мэдрэгч буюу түүнтэй ижил хэрэгслээр тоноглогдсон байх бөгөөд энэ нь: 1/ нисэх багт гэрлэн дохио өгдөг; 2/ нислэгийн үед нисэх багийн гишүүд утааны байрлалыг илрүүлэх боломжтой анхааруулах гэрэл буюу дуут дохио өгдөг.</p>	
<p>D.4. Бүхээгийн доторлогооны материал</p> <p>(a) 1958 оны 01 сарын 01, эсхүл түүнээс өмнө маягаар гэрчилгээжсэн нисэх онгоц нь бүхээгийн дотор тоноглолын анхны томоохон бүрэн солилтын үед багийн гишүүд, эсхүл зорчигчийн ашигладаг бүхээг бүрд 1972 оны 04 сарын 30-нд хүчинтэй болсон АНУ-ын FAR-25-ын шаардлага хангасан материал хэрэглэнэ.</p> <p>(b) Энэ зүйлийн (c)-д зааснаас бусад тохиолдолд, 1958 оны 01 сарын 01-ээс хойш маягаар гэрчилгээжсэн нисэх онгоцны бүхээгийг дараах байдлаар тоноглогдсон байна: (1) хэрэв 1988 оны 08 сарын 20, эсхүл түүнээс хойш, гэхдээ 1990 оны 08 сарын 20-ноос өмнө үйлдвэрлэгдсэн бол, багийн гишүүд, эсхүл зорчигчийн бүхээгийг 1993 оны 03 сарын 29-нд хүчинтэй болсон АНУ-ын FAR-25-д заасан дулаан ялгаруулалтын түвшний тестийн шаардлагыг хангасан материалаар: (i) дээжийг туршсан эхний 2 минутад нийт ялгаруулах дулааны хэмжээ нь квадрат метрт 100 киловатт минутаас хэтрэхгүй байх; (ii) дулаан ялгаруулалтын дээд хэмжээ нь квадрат метрт 100 киловаттаас хэтрэхгүй байх;</p> <p><u>(2) хэрэв 1990 оны 08 сарын 20, эсхүл түүнээс хойш үйлдвэрлэгдсэн бол, багийн гишүүд, эсхүл зорчигчийн бүхээгийг 1993 оны 03 сарын 29-нд хүчинтэй болсон АНУ-ын FAR-25-д заасан дулаан ялгаруулалтын түвшний болон</u></p>	<p>Г.4 Бүхээгийн дотор талын материал</p> <p>(a) Онгоц бүрийн бүхээгийн дотор талыг АНУ-ын FAR-25-ын шаардлагад нийцсэн материалаар доторлосон байна.</p> <p>(б) Маягийн гэрчилгээтэй онгоц бүр нь нисэх багийн гишүүд болон зорчигчдын бүхээгийн доторлогоонд АНУ-ын FAR-25-д заасан, дараах шаардлагыг хангасан материал хэрэглэнэ: 1/ материалын дээжийг туршсан эхний 2 минутын хугацаанд дулаан ялгаруулах нийт хэмжээ 1 м2 талбайд 100 киловатт/минутаас хэтрэхгүй байх; 2/ дулаан ялгаруулах дээд хэмжээ нь 1 м2 бүрд 100 киловаттаас хэтрэхгүй байх;</p>	<p>-“дотор тал”гэснийг “доторлогоо”</p> <p>-2010 онд Amend.2-өөр (2),(3)-р заалт нэмэгдсэн</p> <p>Орчуулга, найруулга зассан</p>

угааны тестийн шаардлага хангасан материалаар;

(3)бүхээгийн дотор бүрдэл хэсгийн анхны томоохон бүрэн солилтын үед багийн гишүүд, эсхүл зорчигчийн бүхээгийг 1993 оны 03 сарын 29-нд хүчинтэй болсон АНУ-ын FAR-25-ын шаардлага хангасан материалаар.

(c) 1958 оны 01 сарын 01-ээс хойш маягаар гэрчилгээжсэн нисэх онгоц нь нислэгийн бүхээгийн суудлаас бусад бүх суудлын зөөлөвчийг 1984 оны 11 сарын 26-нд хүчинтэй болсон АНУ-ын FAR-25-д заасан галаас хамгаалах шаардлагыг хангасан суудлын зөөлөвчөөр тоногдсон байна.

(в) Онгоцны нисэх багийн сандлаас бусад бүх сандлын бүрээс нь АНУ-ын FAR-25-д заасан шаардлагыг хангасан байна.

D.5. Ачааны болон тээшний бүхээг

(a) 1958 оны 01 сарын 01-ээс хойш маягаар гэрчилгээжсэн нисэх онгоцны хувьд:

(1)1986 оны 06 сарын 16-нд хүчинтэй болсон АНУ-ын FAR 25.857–д заасан C, эсхүл D ангиллын ачаа, эсхүл тээшний бүхээгийн эзлэхүүн нь 5.6 м3-ээс (200 cubic feet) дээш бол, тааз болон хана доторлогооны хавтанг дараах материалаар хийсэн байх шаардлагатай:

(i) шилэн даавуугаар бэхжүүлсэн композит (glass fibre reinforced resin); эсхүл

(ii) АНУ-ын FAR 25-ын Appendix F, part III-д заасан тестийн шаардлага хангасан материал; эсхүл

(iii) доторлогооны суурилуулалт нь 1989 оны 03 сарын 20-оос өмнө зөвшөөрөгдсөн бол, хөнгөн цагаан;

(2)2008 оны 01 сарын 01-ээс эхлэн:

(i) 1986 оны 06 сарын 16-нд хүчинтэй болсон АНУ-ын FAR 25.857–д заасан D ангиллын ачааны, эсхүл тээшний бүхээг нь эзлэхүүнээс үл хамааран 1998 оны 02 сарын 17-нд хүчинтэй болсон АНУ-ын FAR 25.857(c) болон 1998 оны 02 сарын 17-нд хүчинтэй болсон FAR 25.858-д заасан C ангиллын бүхээгийн шаардлагыг хангасан байх шаардлагатай; эсхүл

(ii) хэрэв тухайн нисэх онгоц нь зөвхөн ачаанд (all-cargo) ашиглагдаж байгаа бол, D ангиллын ачааны бүхээг нь 1998 оны 02 сарын 17-нд хүчинтэй болсон АНУ-ын FAR 25.857(e)-д заасан E ангиллын ачааны бүхээгийн шаардлагыг хангасан байж болно.

(b) Энэ зүйлийн (a)(1)-ийн зорилгоор, “доторлогоо” (liner) гэсэн нэр томъёо нь галыг аюулгүй тогтоон барих доторлогооны чадварт нөлөөлөх холбоос, эсхүл түгжээ зэрэг загварын хэв шинжийг багтаана.

Г.5 Ачаа болон тээшний бүхээгийн хэсэг

(a) Маягийг хүлээн зөвшөөрөх гэрчилгээ олгогдсон Монгол улсад бүртгэлтэй онгоцнууд нь дараах шаардлагуудыг хангасан байна.

1/ 5.6 шоо метр /200 куб фут/-ээс дээш эзлэхүүнтэй C, D ангиллын ачааны бүхээгийн дээд болон хажуугийн ханыг АНУ-ын FAR 25.857–д тодорхойлсоны дагуу дор заасан материалаар хийсэн байна:

1.1 цардаж бэхжүүлсэн шилэн резинин нийлэг эд;

1.2 АНУ-ын FAR-25-ын /Appendix F part III/- д заасан шалгалтын шаардлага хангасан материал;

1.3 Хөнгөн цагаан хавтан төмөр.

2/ 2010 оны 06-р сарын 01-нээс эхлэн

2.1 D Ангилалд тооцогдох бүх ачаа тээшний бүхээгүүд нь эзлэхүүнээс үл хамааран АНУ-ын FAR 25.857(c) болон FAR 25.858-д тус тус заасны дагуу C ангилалд тавигдах шаардлагуудыг хангасан байна.

2.2 Зөвхөн ачаа, шуудан тээвэрлэх зориулалтаар ашиглагдаж буй онгоцны хувьд, D ангилал бүхий ачаа тээшний бүхээгүүд нь АНУ-ын FAR25.857(e)-д тодорхойлсоны дагуу E ангилалд тавигдах шаардлагуудыг хангасан байж болно.

(б) Энэ хэсгийн (a)-д заасан хананы доторлогооны хавтангууд, холбоос, бэхэлгээ зэрэг нь галын аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн байна.

(в) Бэхэлгээг эс тооцвол доторлогооны хавтангууд нь агаарын

Орчуулга, найруулга
зассан

	хөлгийн их биений бүтцээс салангид байна.	
Хавсралт Е-Нисдэг тэрэг	ХАВСРАЛТ Д. НИСДЭГ ТЭРЭГ/ HELICOPTERS	
Нисдэг тэрэгний гэрчилгээжүүлэлтийн НТЧ-ын нэмэлт шаардлага нь Хавсралт В-д зааснаас гадна дараах шаардлагыг багтаасан байна:	Хавсралт В-д нэмэлт болгож, нисдэг тэргэнд гэрчилгээ олгоход тавигдах НТЧ-ын нэмэлт шаардлагуудад дараах зүйлүүд орно:	
Е.1. Хаалга болон гарц Агаарын тээврийн үйл ажиллагаанд ашиглахаар төлөвлөж байгаа нисдэг тэрэг нь дараах гадна хаалга болон гарцтай байна: (1)дотор ба гадна талаас нь ажиллуулах боломжтой; (2)суудал, суудлын түшлэг, эсхүл бусад төхөөрөмжөөр халхлагдаагүй; (3)дараах хэлбэрээр тоноглогдсон байна: (i) нислэгийн үед аливаа этгээд, эсхүл механик гэмтлийн үр дүнд санаандгүй нээгдэхээс сэргийлсэн түгжээгээр; (ii) тухайн хаалгыг ихэвчлэн нисдэг тэрэгний ачих, буулгах ажиллагаанд ашигладаг бол, хаалга бүрэн хаагдаагүй болон түгжигдээгүй байгаа нь багийн гишүүдэд ил харагдах хэрэгслээр.	Д.1 Хаалга, гарц Нисдэг тэрэг бүр дараах хаалга, гарцтай байна: 1/ дотор ба гадна талаас нь нээж, хааж болох; 2/ хаалга, гарцыг нээж, хаахад суудал, суудлын түшлэг, бусад зүйлүүд саад болохооргүй байх; 3/ дараах хэсгүүдтэй байна: 3.1 нислэгийн үед санамсаргүй онгойлгох, эсхүл механик гэмтлээс болж өөрөө онгойхоос хамгаалагдсан байх; 3.2 хэрэв хаалга нь нисдэг тэрэгний ачих, буулгах ажиллагаанд хэрэглэгддэг бол хаалга бүрэн хаагдаагүй, түгжигдээгүй нь багийн гишүүдэд харагдахаар тэмдэгтэй байна.	Орчуулга, найруулга зассан
Е.2. Дүрвэн гарахад болон гарцад тавих шаардлага Е.2.1. Ослын гарцын тэмдэглэгээ Агаарын тээврийн үйл ажиллагаанд ашиглахаар төлөвлөж байгаа нисдэг тэрэгний ослын гарц бүрийг болон тэдгээрт хүрэх замын чиглэлийг дараах байдлаар ойлгомжтой, тод харагдахуйц тэмдэглэсэн байна: (1)таних тэмдэг болон байрлал нь бүхээгийн өргөнтэй тэнцүү зайнаас танигдахуйц; (2)түүнийг нээх арга хэрэгслийг агуулсан.	Д.2 Аврах гарцын тэмдэг Нисдэг тэрэгний аврах гарц ба түүнд хүрэх арга замыг ил тод, ойлгомжтой тэмдэглэсэн байх ба тэдгээр нь: 1/ кабины өргөнтэй тэнцүү зайнаас харахад танигдахаар байх; 2/ хаалгыг хэрхэн онгойлгох аргыг заасан байх.	Орчуулга, найруулга зассан -“Аврах гарц” гэснийг “Нүүлгэн шилжүүлэх болон гарах гарц”

Дүрмийн боловсруулалтын хэлтэс